



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар Б/49

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулах
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгох хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

| | | |
|--------------------------|---------------|--|
| Ёс зүйн зөвлөлийн дарга: | А.Батсайхан | Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Мөнгөншагай | Хууль зүйн тасгийн дарга |
| | М.Сампилноров | 26 дугаар хорооны нийгмийн ажилтан |
| | М.Оюунцэцэг | Аж ахуйн тасгийн тохижилт, үйлчилгээ хариуцсан ажилтан |
| Нарийн бичгийн дарга: | С.Туулмаа | Төрийн захиргааны хэлтсийн хороо хариуцсан мэргэжилтэн |

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ёс зүйн зөвлөл /А.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

1180200212

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ
СОНГОХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 02

2019.02.26

Хуралдааныг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 17.00 цагт дүүргийн Иргэний танхимд хийв. Хуралдаанд хороодын Зохион байгуулагч, нийгмийн ажилтан нийт 78 албан хаагчид оролцов.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгох хуралдааныг Засаг даргын Тамгын газрын дарга Д.Төмөрбаатар удирдан явуулав.

Хуралдаанд оролцогчдийн ирцийн бүртгэл болон Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан хэлэлцэх асуудлын дараалал, тооллогын комиссийн дүнг хавсаргав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Д.Төмөрбаатар: Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамт олны саналаар сонгохоор хуралдаж байна. Ёс зүйн зөвлөлд хороодын албан хаагчдаас 1 албан хаагчийг санал хураалтаар сонгоно. ЗДТГ-ын Ёс зүйн зөвлөлийн гишүүдэд нэр дэвшиж дэмжигдсэн 4 гишүүнийг танилцуулав.

- 1.Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай
- 2.ТГХШХ-ийн дарга А.Батсайхан
- 3 Хороо хариуцсан мэргэжилтэн С.Туулмаа
4. ААТ-ийн үйлчилгээ тохижилт хариуцсан ажилтан М.Оюунцэцэг

ЗДТГ-ын дарга: 26-р хорооны Нийгмийн ажилтан М.Сампилноровыг нэр дэвшүүлэхээр санал оруулж байна.

10 дугаар хорооны Зохион байгуулагч Н.Баярманлай: 25-р хорооны Нийгмийн ажилтан Р.Ганбаярыг нэр дэвшүүлэхээр санал оруулж байна.

26-р хорооны Зохион байгуулагч О.Ханрайсүрэн: 20-р хорооны Зохион байгуулагч П.Халиунсүрэнг нэр дэвшүүлэхээр санал оруулж байна.

Гарсан санал

26-р хорооны Нийгмийн ажилтан М.Сампилноров: Зөвшөөрч байна.

20-р хорооны Зохион байгуулагч П.Халиунсүрэн: Татгалзаж байна.

25-р хорооны Нийгмийн ажилтан Р.Ганбаяр: Татгалзаж байна.

ЗДТГ-ын дарга Д.Төмөрбаатар: Нэр дэвшсэн албан хаагч тус бүрээс өөрсдийн саналыг авсан. Одоо санал хураалтын үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд саналыг аль хэлбэрээр авах талаар нийт албан хаагчдаас санал авна. Хуралд оролцсон албан хаагчдын дийлэнх олонхын саналаар санал хураалтыг илээр гар өргөж авахаар боллоо.

Тооллогын комиссыг байгуулна. Тооллогын комиссд НХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Баярмаа, ТЗУХ-ийн мэргэжилтэн Б.Болдбаатар, А.Жамбалсүрэн, Б.Бямбажаргал, ТГХШХ-ийн мэргэжилтэн Золзаяа нарыг нэр дэвшүүлж баталлаа. Ёс зүйн зөвлөлийн гишүүдэд санал оруулсан 5 албан хаагчдыг илээр гар өргөж санал хураалт явууллаа. Одоо ёс зүйн зөвлөлийн даргыг сонгох явцыг эхлүүлнэ. Ёс зүйн зөвлөлийн даргад ТГХШХ-ийн дарга А.Батсайханыг нэр дэвшүүлж илээр гар өргөж санал хураалаа. Хуралд оролцогч 126 албан хаагчдын дийлэнх олонхын саналаар ёс зүйн зөвлөлийн даргаар А.Батсайхан сонгогдлоо.

Санал хураалт илээр гар өргөж тооллогын комисс саналыг тоолж саналыг нэгтгэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хуралдаанд оролцсон 126 албан хаагчдын дийлэнх олонхын саналаар ёс зүйн хорооны даргаар ТГХШХ-ийн дарга А.Батсайхан, нарийн бичгийн даргаар ТЗУХ-ийн мэргэжилтэн С.Туулмаа, гишүүдэд Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай, ААТ-ийн үйлчилгээ, тохижилт хариуцсан ажилтан М.Оюунцэцэг, 26 дугаар хорооны Нийгмийн ажилтан М.Сампилноров нар сонгогдлоо.

Хуралдааныг 17.55 цагт дуусгав.

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА  Д.ТӨМӨРБААТАР

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХТУЯА

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ
СОНГОХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 01

2019.02.26

Хуралдааныг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 16.00 цагт дүүргийн Иргэний танхимд хийв. Хуралдаанд ЗДТГ-ын хэлтэс тасгийн дарга, албан хаагчид оролцов. Нийт 48 албан хаагчид оролцлоо.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг сонгох хуралдааныг Засаг даргын Тамгын газрын дарга Д.Төмөрбаатар удирдан явуулав.

Хуралдаанд оролцогчдийн ирцийн бүртгэл болон Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан хэлэлцэх асуудлын дараалал, тооллогын комиссийн дүнг хавсаргав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Д.Төмөрбаатар: Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг хамт олны саналаар сонгохоор хуралдаж байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу ёс зүйн зөвлөл нь 3-7 гишүүнтэй байхаар заасан байна. Олон гишүүнтэй байх нь ажил явуулахад хүндрэлтэй байх магадлалтай тул 5 гишүүнтэй байх нь зүйтэй гэсэн саналтай байна. 2018 онд ажиллаж байсан Ёс зүйн хороог Ёс зүйн зөвлөл болгож өөрчлөөд хуучин бүрэлдэхүүнээр ажиллуулах саналтай байна. Хууль эрх зүйн хувьд ямар нэгэн зөрчилгүй.

ТЗУХ-ын дарга Т.Сүхбаатар: 2018 оын 5-р сард Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах санал ирсэн. Ингээд дүүргийн Ёс зүйн хороог байгуулсан. Энэ хугацаанд хүндрэлтэй асуудлууд олон байсан. Улс төрийн албан хаагчидтай холбоотой асуудлууд олон гардаг. Одоо тусдаа журам гарч зохицуулагдана. Гишүүд 3 жилийн хугацаатай томилогдоно. Ёс зүйн зөвлөл журмаа батална. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр томилох саналтай байна. Би ёс зүйн зөвлөлийн даргын ажлаас татгалзаж байна.

ААНТ-ийн дарга Сумъяабазар: Төрийн үйлчилгээний албан хаагчаас зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах саналтай байна.

Цэргийн штабын дарга Г.Ялалт: Зөвлөлийн гишүүд дандаа эрэгтэй албан хаагчид байна. Иймд эмэгтэй албан хаагчдаас оруулах саналтай байна.

Хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн С.Мижиддорж: Ёс зүйн хороонд 2 удаа сонгогдож ажилласан. Олон асуудал байна. Хүний нөөцийн мэргэжилтэн ёс зүйн зөвлөлд орж ажиллах нь буруу гэж бодож байна. Би ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнээс нэрээ татаж байна.

СТСХ-ийн дарга Батцэцэг: Ёс зүйн зөвлөлд ихэвчлэн хэлтсийн дарга нар байна. Мэргэжилтэн оруулах саналтай байна.

ТЗУХ-ын дарга Т.Сүхбаатар ёс зүйн зөвлөлд Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай, ХХҮХ-ийн дарга Тулгабаатар, ААТ-ийн ахлах нягтлан бодогч Золзаяа, НХХ-ийн ахлах мэргэжилтэн Баярмаа, ХХҮХ-ийн мэргэжилтэн Алтаннавч нарыг нэр дэвшүүлэв.

ААТ-ийн дарга Сумъяабазар: ААТ-ийн менежер Оюунцэцэгийг нэр дэвшүүлж байна.

Цэргийн штабын дарга Г.Ялалт: ТГХШХ-ийн дарга Батсайхан, Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай, НХХ-ийн дарга Энххорол нарыг нэр дэвшүүлж байна.

ТНААХ-ийн дарга Н.Мөнгөн-Эрдэнэ: Хороо хариуцсан мэргэжилтэн С.Туулмаа, ТНААХ-ийн мэргэжилтэн Ж.Энх-Төгсмаа нарыг нэр дэвшүүлж байна.

Нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зогсоож Ёс зүйн зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлэх саналтай 4 албан хаагчдыг танилцуулав.

1. Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай
2. ТГХШХ-ийн дарга А.Батсайхан
3. Хороо хариуцсан мэргэжилтэн С.Туулмаа
4. ААТ-ийн үйлчилгээ тохижилт хариуцсан ажилтан М.Оюунцэцэг нарыг нэр дэвшүүлж албан хаагч тус бүрээс өөрсдийнх нь саналыг сонслоо.

Гарсан санал:

Хууль зүйн тасгийн дарга Б.Мөнгөншагай: Зөвшөөрч байна

ТГХШХ-ийн дарга А.Батсайхан: Зөвшөөрч байна

ТЗУХ-ийн Хороо хариуцсан мэргэжилтэн С.Туулмаа: Зөвшөөрч байна.

ААТ-ийн үйлчилгээ тохижилт хариуцсан ажилтан М.Оюунцэцэг: Зөвшөөрч байна.

Д.Төмөрбаатар: Нэр дэвшсэн албан хаагч тус бүрээс өөрсдийн саналыг авч дууслаа. ТЗУХ-ийн дарга, хүний нөөц, ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн нар Ёс зүйн зөвлөлийн асуудлаар зөвлөгөө өгөх, удирдлагад мэдээлэх чиглэлээр хамтарч ажиллана. Одоо санал хураалтын үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд саналыг аль хэлбэрээр авах талаар нийт албан хаагчдаас санал авна.Хуралд оролцсон албан хаагчдын дийлэнх олонхын саналаар санал хураалтыг илээр гар өргөж авхаар боллоо.

Тооллогын комиссыг байгуулна. Тооллогын комиссд НХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Баярмаа, ТЗУХ-ийн мэргэжилтэн Б.Болдбаатар, А.Жамбалсүрэн,Б.Бямбажаргал, ТГХШХ-ийн мэргэжилтэн Золзаяа нарыг нэр

дэвшүүлж баталлаа. Санал хураалт илээр гар өргөж тооллогын комисс саналыг тоолж саналыг нэгтгэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэр дэвшүүлсэн 4 албан хаагчдыг хороодын Зохион байгуулагч, Нийгмийн ажилтан нарын саналыг авч нэгтгэн эцсийн дүн мэдээ гарна.

Хуралдааныг 16.50 цагт дуусгав.

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХТУЯА